

Дугшихын балгас

Уламбаярын Эрдэнэбат^{1, *}

Товч агуулга: Дугшихын балгасаас илэрсэн гурван дээжийг Япон улсын C14 лабораторид илгээж он цагийг тогтоолгоход 1270-1370 оны хооронд буюу Их Юань улсын үед холбогдох нь тодорхой болов. Энэхүү өгүүлэлд Дугшихын балгасаас олдсон төмрийн бэлдэц, төмөр болон зэс зоосыг тэнд байсан гар үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай холбон тайлбарлахыг оролдсон байна. Дугшихын балгас нь Монголын эзэнт гүрэн болон түүний дараах үед Хархорум хот руу аян жин тээдэг худалдааны замын нэг чухал зангилаа газар байжээ.

Түлхүүр үг: Дугшихын балгас, Монголын эзэнт гүрэн, Юань улс, хот суурины археологи

Удиртгал

Монгол улсын Өмнөговь аймгийн Цогт-Овоо сумын Бор тээг баг буюу 2-р багийн нутагт, сумын төвөөс зүүн урагш 15 км зайтай Дугшихын балгас оршино (Зураг 1). Нутгийн ардын ярианд, Тогоонтөмөр хааны үеийн хот гэж ярьдаг. 1957 онд Монголын нэрт эрдэмтэн, археологич Х.Пэрлээ гуай үзэж эрдэм шинжилгээний эргэлтэнд анх оруулжээ. Дугшихын шуудуу гэдэг, эрт цагт газар тариалан эрхэлж байсан ор мөр бүхий газрын ойролцоо, Дугшихын гурван худаг хэмээх газрын урд, хойд, зүүн талаар чулуу шавар холилдуулан барьсан олон барилга байсны ул мөр мэдэгдсэн байна. Гэвч нэг ч барилгын тодорхой хэлбэрийг мэдэж болохооргүй эвдэрчээ. Барилгыг түр байдалтай яаравчлан барьснаас тийнхүү хялбархан баларч алга болсон бололтой. Барилга олон байсны дээр сав суулга их олон байсны баримт буй. “Юань улсын шаазан” хэмээх ваар шаазангийн хагархай тун элбэг олдож байсан. Үүгээр үзэхэд, Дугшихын балгас XIV зууны эцсээр /1368-1370 онд/ байгуулсан, Тогтоонтөмөр хааны цэргийн түр суурин байж болох юм гэсэн дүгнэлт хийжээ (Пэрлээ 1963: 29). Түүнээс хойш Дугшихын балгасыг археологичид зам гудас сонирхон үзэж байсан боловч малтлага судалгаа хийж, бүтэц зохион байгуулалт, үүрэг зориулалт, он цагийг баттай тогтоох судалгааны ажил хийгдэлгүй 70 шахам жилийн нүүрийг үзсэн байна.

Анхны малтлага судалгаа

2021 онд МУИС-ийн Шинжлэх Ухааны Сургууль,

Японы Шова Эмэгтэйчүүдийн Их Сургууль хамтран “Чингис хааны далан: Олон улсын хамтын ажиллагаа” эрдэм шинжилгээний төслийг хэрэгжүүлэх гэрээ байгуулж, түүнээс хойш жил бүр археологийн хээрийн судалгааны ажлыг амжилттай зохион байгуулсаар ирлээ. Тус төслийн хүрээнд 2022 оны 9 дүгээр сард Өмнөговь аймгийн Цогт-Овоо сумын нутагт орших Дугшихын балгасанд ажиллаж зарим түүвэр олдвор хэрэглэгдэхүүн цуглуулж эрдэм шинжилгээний тайлан бичсэн билээ (Эрдэнэбат нар 2022: 213-219).


Биднийг 2022 онд ирж үзэхэд, Дугшихын худгийн хойд Цагаан толгойн энгэрээр чулуугаар дөрвөлжлөн өрсөн булш нэлээд байсныг тонож сүйтгэсэн байлаа. Дугшихын балгас бол Монголын дундад зууны түүх, археологийн төдий л судлагдаагүй, нэн яаралтай хадгалж хамгаалах, судлан шинжлэх шаардлагатай дурсгал юм. Ялангуяа, Монголын эзэнт гүрэн ба түүний дараах үеийн зам харилцаа, өртөө, худалдаа, гар үйлдвэрлэл зэрэг эдийн засгийн асуудлыг тодруулахад чухал ач холбогдолтой археологийн дурсгалт газар болно.

МУИС, Японы Шова Эмэгтэйчүүдийн Их Сургууль хамтарсан багийнхан энэ дурсгал дээр археологийн малтлага, хайгуул судалгааны ажлыг шинээр эхлүүлэх, дурсгалын бүтэц зохион байгуулалт, байгуулагдсан болон идэвхтэй ашиглагдаж байсан он цаг, үүрэг зориулалтын талаар эрдэм шинжилгээний шинэ эх хэрэглэгдэхүүн бүрдүүлэхэд чиглэсэн хээрийн шинжилгээний ажлыг 2024 оны намар зохион байгуулав (Эрдэнэбат нар 2024: 80-82)¹.

¹ МУИС, ШУС, Антропологи, Археологийн тэнхим, Нүүдэлчдийн археологийн хүрээлэн

* Холбоо барих зохиогч: u_erdenebat@num.edu.mn
<https://orcid.org/0000-0003-0867-3691>

¹ 2024 оны хээрийн шинжилгээнд МУИС-ийн ШУС-ийн Антропологи, Археологийн тэнхимийн эрхлэгч, профессор У.Эрдэнэбат, Японы Шова Эмэгтэйчүүдийн Их Сургуулийн профессор Хүсэл Боржигин, МУИС-ийн Түүхийн тэнхимийн профессор Ж.Урангуя, Япон Улсын Токиогийн Гадаад хэл соёлын сургуулийн хүндэт профессор Хироши Футаки, МУИС-ийн Антропологи, Археологийн тэнхимийн докторант А.Золжаргал, Б.Дашидорж, оюутан Э.Билгүүн, Б.Отгонгалсан, М.Шагжсжав, Э.Далайжаргал, Х.Мөнх-Учрал, тозооч П.Мөнхдэлгэр, жолооч А.Нямхүү, Н.Батбаатар нар ажилласан.



Зураг 1. Өмнөговь аймгийн Цогт-Овоо сумын нутаг Дугшихын балгасын байрлал

“Дугших” хэмээх нэрийн тухай товч өгүүлэхэд, говийнхон “худаг дугшаана” гэж ярьдаг нь ус ундрахыг хүлээнэ гэсэн үг. Мал усалж байхад худгийн ус шавхагдахад “ус шавхарчихлаа, дугшаая”, “жаахан дугшиг дээ” гэж хэлдэг. Дугшихын баруун хойд талд орших, орой дээрээ овоотой хоёр хөглийн баруун талынхыг Баруун Цагаан овоо, зүүн талынхыг Зүүн Цагаан овоо гэнэ. Зүүн Цагаан овоо буюу Цагаан толгойн нь орой дээр цагаан чулуугаар дөрвөлжлөн өрсөн эртний байгууламж бий (48 Т 0521861, UTM 4908686, далайн түвшнээс дээш 1236 м өндөр). Үүний хойд тал 20 м, зүүн тал 20,5 м, урд тал 18,5 м, баруун тал 21 м хэмжээтэй. Дөрвөн буланд нь том чулуу тавьсан. Дөрвөлжин хүрээний дотор талд шороо асгаж тэгшилж зассан дэвсэг мэт харагдана.

Одоо Цогт-Овоо сумын төвийн урд байгаа хоолойг Дугшихын хоолой буюу Дугшихын шуудуу гэдэг. Засмал зам тавихаас өмнө энэ хавиар явахын аргагүй шавар ус тогтдог газар байжээ. Тиймээс нэлээд холуур тойрч явахаас аргагүй байсан. Х.Пэрлээ гуайн тэмдэглэснээр, Бухат-Долоон гэдэг газраас Дугшихын хойд хөндий хоолойгоор татсан тарианы том шуудууны ор байдаг юм байна. Үүнээс Дугшихын шуудуу гэдэг нэр үүссэн гэжээ (Пэрлээ 1963: 29). Нутгийн ардын ярьснаар, Дугшихаас зүүншээ 20-иод км Билгэхийн манханаас шуудуу буюу ус энд ирдэг.

Засмал дээгүүр нь гарч байгаа хэсгийг Дугшихын Улаан тойром гэж ярьдаг байна.

1957 онд Х.Пэрлээ гуай Дугшихын балгасанд ирээд боржин тээрэм 1, бэсрэг боржин уур 1 байна, бас галт уулын хүрмэн чулуугаар хийсэн гар тээрмийн чулуу олдож байна гэж тэмдэглэжээ (Пэрлээ 1963: 29). Нутгийн ардын ярианд, Дугшихын балгас бол дээр үед жинчдийг хооллож ундалж байсан газар гэдэг. Одоо засмал замын баруун талаар тариа тарьж байсан газар нь байдаг. Нутгийн хөгшчүүд, хар будаа тарьж байсан, хар тариа ч гэдэг, одоогийнхоор арвай тарьж байсан байх гэлцдэг. Тариа тарьж байсан газар руугаа татсан шуудуу нь одоо элсэнд дарагдаад алга болсон. Дугшихын Улаан хоолой хэмээх энэ хоолойд тал талын уулсаас 30-40 км газраас ус бууж тогтдог. Гэхдээ ус нь газартаа шингээд их зөөлөн бууж ирдэг гэнэ. Энэ газар дээр үед хар будаа, олс тарьж байсан. Хятадууд тарьж байсан гэж ярьдаг байжээ. Дээр үед зовсон зүдэрсэн улсууд их явж байсан жингийн зам байсан учраас Дугшихын балгасанд битгий бууж бай гэж настайчууд захидаг байсан. Буувал хүүхэд шуухад өвддөг, мал тогтдоггүй гэдэг. Эндээс зүүн урагшаа 30 км-т Ямаан шандны сэтэрхий хэц байдаг. Түүгээр жингийн цуваа гарч байсан. Дундговийн Өлзийтийн Хөнжилийн араар бас нэг сэтэрхий бий. Шар зам түүгээр явж байсан гэж ярьж байв.

Цогт-Овоо сумаас баруун хойш 35 км, Замын шанд багийн нутагт Сэрүүн дуганын турь гэж бий. Тээрэм толгой гэж бий. Тэр Сэрүүн дуганыг Тогоонтөмөр хаан Бээжингээс хөөгдөөд явж байхдаа жил гаруй болсон гэж ярьдаг. Дугшихын хэцийн зүүн талд, сумын төвийн урд талд ус тогтдог хоолойд сайн харвал товгордуу бондгор толгой харагдана. Түүнийг Будаан таваг гэж нэрлэдэг байсан. Энэ хавиас тээрмийн чулуу нэлээд олддог байсны заримаас Цогт-Овоо сумын Соёлын төвд аваачиж тавьсан ажээ².

Дугшихын балгас нь ерөнхийдөө гадуураа нэгдсэн хамгаалалтын хэрэм далан гэж байхгүй. Эртний хотын дэвсгэрт хайгуул хийж үзэхэд Цагаан толгойн энгэр, Дугшихын худгийн зүүн талаар хамгийн олон барилгын ором мэдэгдэж буй (Зураг 2). Түүнээс урагшаа харьцангуй цөөн барилгатай, харин зүүншээ бүр цөөн ором муухан мэдэгдэнэ. Хэсэг тус бүрдээ дундуураа гарсан өргөн гудамтай, түүний хоёр талаар эгнүүлэн барьсан барилгуудтай байжээ. Дээврийн ваарны хагархай, барилгын чимэглэл, шатаасан тоосго ер харагдахгүй байхаас үзвэл барилгууд нь мод шавраар хийсэн тун энгийн хийцтэй, шавар тагзнууд байсан бололтой. Энэ барилгууд нь хэмжээгээр жижиг бөгөөд ханзан халаалтын системтэй байжээ. Барилгын гадна талаар хашаа, малын саравч байсан мэт бөгөөд хашаа хороо байсны ором халцархай газар, цагаан

цайвар өнгийн чулуугаар газар эгнүүлэн нөмөрлөж хашсан өрлөг маягийн зүйл үлджээ. Ялангуяа чулуун хорооны үлдэгдэл нь салхин талдаа чулуугаар дарсан нөмөртэй, жингийн тэмээ хэвтүүлэхэд багтахаар саравч маягийн зүйл байсан бололтой.

Дугшихын балгасан дээр хайгуул хийхэд эргэн тойрон 1 км радиустай газраас хятад шаазангийн хагархай, шавар савны хэлтэрхий, хятад зоос, тэрэгний цөн, төмрийн бэлдэц хэмээх зүйл элбэг олдож байна. Хятад шаазангийн хагархай нь Монголын эртний нийслэл Хархорум, Шаазан толгой зэрэг Монголын эзэнт гүрний хот сууринаас элбэг олддог материалтай ижил, бас түүнээс он цагийн хувьд хожуу үеийн ч материал олдож байна.

1. Дугшихын балгас – Сорилтын малтлага-1

Дугшихын Зүүн Цагаан овоо буюу орой дээрээ дөрвөлжин чулуун байгууламжтай овоотой хөтлөөс баруун урагш, Дугшихын худгаас баруун урагш 460 м зайтай оршино. Хойд талаараа элсэн довцог бүхий сэвхүүлтэй, товгор тэгш газрын хойд захад газрын өнгөн хөрсөн дээр жижгэвтэр цайвар цагаан өнгийн чулуугаар дугуйруулан өрсөн булш гэмээр байгууламжууд байдаг. Бидний малтахаар сонгож авсан байгууламж 260 x 220 см хэмжээтэй, чулуун өрлөг нь гонзгой дөрвөлжин хэлбэртэй, хавтгай дараастай. Энд газрын өнгөн хөрсөн дээр жижгэвтэр цайвар цагаан өнгийн чулуугаар дугуйруулан өрсөн 7 байгууламж

² Дугших хэмээх нэрийн тухай, Дугшихын балгас, түүний ойр орчмын газар усны тухай нутгийн домог хуучилсан Өмнөговь аймгийн Цогт-Овоо сумын 2-р багийн малчин Буянтын Малчинхүү (1968) гуайд талархал илэрхийлье.



Зураг 2. Дугшихын балгасын олон барилгын суурь мэдэгдэж буй гол хэсэг

нэг дор байрлана. Зарим нь дугуй хэлбэртэй, зарим нь дөрвөлжин хэлбэртэй. Энэхүү малтан судалсан дурсгал тэдгээр чулуун байгууламжийн хамгийн баруун захад байрлана. Байршил: 48 Т 0521360, UTM 4908106, далайн түвшнээс дээш 1224 м өндөр. Малтлагаар цагаан паалантай ваарны бөөрцгийн хагархай, шатсан мод, бог малын ясны жижиг хугархай хэсгүүд олдсон. Улаан шаварлаг хөрстэй. Ямар нэгэн зохион байгуулалт, хөрсний өөрчлөлт, толбо илрээгүй. 40 см гүнд эх газрын ул хөрс гарсан.

2. Дугшихын балгас – Сорилтын малтлага-2

Сорилтын малтлага 1-ээс зүүн урагш 4 м зайтай оршино. Чулуугаар дугуйруулан өрсөн хавтгай дараастай. Голч 230 см. Байршил: 48 Т 0521359, UTM 4908098, далайн түвшнээс дээш 1223 м өндөр. Өнгөн хөрсний цэвэрлэгээний явцад талбайн төв гол хэсгээс 10 см гүнд хар саарал паалантай ваарны хагархай 2 ш гарсан. Ямар нэгэн толбо, хөрсний өөрчлөлт мэдэгдээгүй. Малтлагын гүн 50 см болоход эх газрын ул хөрс гарсан. Энэхүү сорилтын хоёр малтлагаас үзэхэд энэ дөрвөлжин, дугуй чулуун дараастай байгууламжууд нь булш оршуулга биш бололтой.

3. Дугшихын балгас – Сорилтын малтлага-3

Сорилтын малтлага 2-оос зүүн тийш 485 м зайтай, Дугшихын Цагаан толгойн чанх урд талд, борооны усанд тогтсон жижиг тойрмын баруун урд оршино. Байршил: 49 Т 0521826, UTM 4908212, далайн түвшнээс дээш 1215 м өндөр. Газрын өнгөн хөрсөн дээр жижгэвтэр чулуугаар дөрвөлжлөн өрсөн, 550 см урт, 350 см өргөн хэмжээтэй хавтгай өрлөгөөр мэдэгдэж байв. Байгууламжийн дээд талын чулуун өрлөг хоёр үе. 10 см зузаан хавтгай хадаар дөрвөлжлөн өрж, түүний дээр жижиг чулуугаар 3-4 үе эгнүүлэн өрсөн зохион байгуулалттай.

Өнгөн хөрсний цэвэрлэгээний явцад малын ясны жижиг хугархай талбайн төв болон баруун хэсгээс гарч байв. Мөн шаргал өнгийн паалантай шавар савны ёроолын хэсэг олдов. Түүний зэрэгцээ талбайн зүүн урд булангаас шатсан үнс, жижиг нүүрс бүхий толбо 10 см гүн илэрсэн. Байгууламжийн бусад хэсгүүд өнгөн хөрсөн дээр нэг үе чулуу дэвсэж өрсөн байхад энэхүү шатсан үнс бүхий газар бусдаас илүү том чулуугаар газрын өнгөн хөрснөөс 60 см гүнд гурван эгнээ зэрэгцүүлэн дээрээс нь хавтгай хадаар таглаж тавьсан байв. Энэ хэсгийг цэвэрлэн малтах явцад 30 см гүнээс ногоон өнгийн паалантай шаазан аяганы ёроолын хагархай, адууны шүдний хугархай хэсгүүд гарсан.

Дөрвөлжин өрлөгийн дотор талд гол тэнхлэгийг дайруулан зүүн талд нь 400 см урт, 100 см урт

сорилтын суваг малтав. Сувгийн малтлагыг эх газрын ул хөрсөнд тултал хөрсний хатуу хэсгийг үлдээж зөөлөн сул хэсгийг халбагадан цэвэрлэх аргаар зохион явуулав. Малтлагын гүн байгууламжийн хойд хананд 66 см, урд хананд 20 см, төв хэсгээр 60 см хүрсэн болно. Малтлагын явцад малын ясны жижиг хэлтэрхий, адууны шүдний бутархай энд тэндээс олдсон. Яг энэ хэсгээс шатсан үнс нурам болон өөр ямар нэгэн толбо мэдэгдэхгүй, харин чулуун өрлөгийн доор дотроо жижиг хайрга бүхий элсэрсэг хөрс 30 см, түүний дараа 10 см зузаан, саарал өнгөтэй, дотроо бага зэрэг үнстэй давхарга илэрсэн. Энэхүү давхаргаас 40 см гүнээс малын шатаагүй ясны жижиг хугархай хэсгүүд гарснаас дээж авав. Үүний дор 40-50 см гүнд 2-6 см нимгэн улаан хүрэн зостой, шавар давхарга гарсан. Түүний дороос 20 см зузаан, шаргал саарал өнгөтэй, улаан шавартай холилдон үе гарав. Энэхүү давхаргаас 66 см гүнээс бог малын эрүү, тугалмай эвэр, чөмөгний хугархай яс олдсоноос дээж авав. Талбайн төв тэнхлэгийн баруун талд хийсэн малтлагаар, зөөлөн хөрсийг дагуулан 250 x 150 см талбайд өргөтгөж малтсан. Баруун ханын төв хэсэгт дотроо үнс, шатсан мод, малын ясны жижиг хугархай бүхий толбо илэрсэн. Хэмжээ нь 70 x 30 см. Үүнийг баруун ханын зүсэлтэн дээр харахад тогоо хэлбэртэй. 30 см зузаан. Энэ толбо шаргал өнгийн элсэрхэг, улаан хөрс холилдон орчны хөрснөөс тод ялгарч харагдаж байв. Хонхор тогоо нь мөн жижгэвтэр чулуугаар дүүргэгдсэн байв.

Дөрвөлжин өрлөгийн баруун урд буланд өнгөн хөрсний цэвэрлэгээний явцад гал түлсэн бүдэг ором мэдэгдсэн. Энэ нь талбайн урд ханын зүсэлтэн дээр илүү тод мэдэгдсэн. Эндээс мөн шатсан модны жижиг хэсгүүд, малын шатаагаагүй ясны жижиг хэлтэрхий гарсан. Толбоны хэмжээ 50 x 20 см. Энэхүү толбыг зүсэж малтахад 20 см өргөн, 23 см өндөр суваг маягийн зүйл болох нь мэдэгдсэн. Сувгийн дөрвөн талыг түүхий тоосгоор хашсан нь 5 см зузаан, өргөн нь 20 см хэмжээтэй. Доод хэсгээр ихэд шатаж түлэгдсэн, хар тортогтой үе 2 см, саарал үнс 3 см, нийт 5 см давхарга үлдсэн байлаа. Энэхүү дөрвөлжин хоолойгоор зуухнаас гарсан халуун утаа гүйж байсан тул дотор талыг малтан үзэхэд нэлэнхүйдээ үнс гарсан болно. Үүнээс үзэхэд Дугшихын балгасанд байгаа гонзгой дөрвөлжин хэлбэртэй, чулуу дэвссэн байгууламжууд нь булш оршуулга биш, харин хүн сууж байсан жижиг сууцтай холбоотой бололтой.

4. Дугшихын балгас – Сорилтын малтлага-4

Сорилтын малтлага 1-ээс зүүн зүгт 386 м, сорилтын малтлага 3-аас баруун тийш 90 м зайтай, Дугшихын Зүүн Цагаан овооны урд энгэрт, Дугшихын худгаас зүүнш 300 м зайтай, одоо Бор Тээг багаас

сумын төв явдаг шороон замын яг дэргэд оршино. Чулуун өрлөгийн тал хэсэг замд дайрагдаж ил гарсан байв. Байршил: 48 Т 0521741, UTM 4908172, далайн түвшнээс дээш 1221 м өндөрт оршино. Энэ байгууламж нь газрын өнгөн хөрсөн дээр том чулуугаар дугуйруулан өрсөн цагариг хэлбэрийн дараастай. Голч 400 см. Цагаригийн дотор талын баруун урд буланд газрын өнгөн хөрснөөс шавар пийшингийн өрлөгийн булан мэт зүйл цухуйж байв. Үүнийг шалгаж малтаж үзвэл, 136 х 53 х 10 см хэмжээтэй хуудсан хад байв. Хавтгай хадны хажуу талыг цэвэрлэх явцад цагариган өрлөгийн дотор талд 15 см гүнээс дундуураа хугарсан хавтгай төмөр гарсан. Улмаар талбайг тэлж, чулуун цагаригийн дотор талд бүх талбайгаар малтахад 20 см гүнд, цагаригийн зүүн урд хэсгээс хар өнгийн паалантай ваарны хагархай, бог малын ясны жижиг хэлтэрхий, баруун урд хэсгээс шатсан модны нүүрс бүхий шатсан толбо илэрсэн. Чулуун цагаригийн голоос ямар ч чулуу гараагүй. Харин зүүн урд байсан хавтгай чулууны зүүн талд улаан өнгийн шатсан шаварлаг толбо орчны элсэн шаргал хөрснөөс ялгарч мэдэгдэж байв. Шатсан толбоны хэмжээ 40 х 20 см. Толбыг цэвэрлэхэд өмнө гарсан төмрийн ижил, зориулалт нь үл мэдэгдэх хавтгай төмрийн хоёр хугархай гарсан. Төмрийн дархны газар ямар нэг эдлэл хийхэд цутгуураас гарсан хэрэггүй хэсгийг тасдаж хаядаг. Энэ хоёр хугархай бол тиймэрхүү үйлдвэрлэлийн процессоос гарсан хаягдал бололтой.

5. Дугшихын балгас – Сорилтын малтлага-5

Дугшихын Цагаан толгойн урд энгэрт гадуураа чулуун хашаа хүрээтэй, гуч шахам барилгын ором мэдэгдэх бөгөөд Дугшихын худгаас чанх урагш 500 м орчим зайд энэхүү сорилтын малтлага хийсэн талбай байрлана. Уг дурсгал эртний барилгын ором гэдэг нь газрын гадарга дээр энгийн нүдээр төдийлэн сайн мэдэгдэхгүй. Харин дрон нисгэж дээрээс нь харвал, зохион байгуулалт нь тодорхой харагдана. Мөн барилгын гадуур хашаа хүрээ буюу шавар хэрмийн хана байсан гэмээр ором орчны ургамлын бүрхэвч дундаас халцгайрсан байдлаар ялгарч харагдана. Гаднах хашаа буюу хэрмийн ор нь тэгш өнцөгт дөрвөлжин хэлбэртэй, баруун хойноос зүүн урагш чиглэлтэй сунгаж барьсан байжээ. Урт нь хойд талын хана 25 м, зүүн талын хана 17 м, урд талын хана 21 м, баруун талын хана 18 м. Өргөн нь бүх талдаа 1,5 м хэмжээтэй, хашаа хэрмийн ханын суурийг чулуугаар өрж, түүхий шавар тоосгоор хийж байсан бололтой. Хойд, баруун, урд хэсэгт дан чулуун суурь нь хадгалагдаж үлдсэн. Харин зүүн талдаа зохион байгуулалт нь бараг мэдэгдэхгүй болжээ (Зураг 3).

Энэ хашаа хэрмийн доторх талбайн зүүн хойд хэсэгт нь хавтгай чулууг босоогоор газарт суулгаж

дөрвөлжлөн тавьсан байгууламж ил харагдаж байлаа. Өнгөн хөрсний цэвэрлэгээгээр ургамлын бүрхэвчийг нь хуулж цэвэрлэсний дараа тухайн байгууламжийн дүр зураг, зохион байгуулалт мэдэгдэж эхлэв. Уг байгууламжийн хэмжээ: Хойд талын чулуун ханын урт 250 см, хойд ханын гол хэсгээс урагш сунгаж өрсөн чулуун өрлөгтэй. Түүний хэмжээ: уртааш 190 см, эдгээр ханыг бүрдүүлж буй чулууны зузаан 5-7 см, дундаж урт 45 см, тухайн газрын цайвар цагаан чулуунаас өөр хадаар үйлджээ. Нутгийн иргэдийн хэлснээр, ийм чулуу Дугшихын балгасаас зүүншээ алсад харагдах ууланд байдаг гэнэ. Дотор талд нь үнс нурам бүхий дугуй нүх илэрсэн нь ханзан халаалтынх бололтой байв. Малтлага цэвэрлэгээний явцад үнсний хамт бог малын ясны хэлтэрхий ихээр гарч байв.

Энд байсан барилга нь түүхий тоосгоор өрсөн ханатай, тэгш өнцөгт хэлбэрийн багавтар сууц байжээ. Түүний хойд ханын урт 680 см, зузаан 85 см. Ханын зүүн хэсгээр түүхий тоосгон өрлөг сайтар хадгалагдан үлдсэн. Харин баруун хэсэг нь эвдэрч мэдэгдэхгүй болжээ. Зүүн талын ханын урт 460 см, баруун талын хана 460 см урт. Сууцны төв хэсгээс галын ором бүхий үнс, тортогны дундаас хагас дугуй хэлбэрээр өрж үйлдсэн түүхий тоосгон өрлөгтэй зуухны үлдэгдэл, түүнээс гарсан гурван салаа суваг бүхий шалны халаалтын өрлөг илэрсэн. Зуухан дотор шатсан үнс, тортог ихээр хуримтлагдсан бөгөөд бог малын ясны хэлтэрхий нэлээд гарсан.

Сорилтын малтлага 5-аас: 1) Дөрвөлжин чулуун хашлагын дотор талд 10 см гүнээс гонзгой хэлбэртэй, сэнж хэсэг нь сэтгэрч хугарсан чулуун зүүлт гарсан. Нэг талын үзүүр хэсгийг нарийсган зассан. Өндөр 1,5 см. 2) Зэс ээмэгний шилбэ. Асуултын тэмдэг хэлбэртэй. Унжлага хугарсан. Өндөр 3,5 см. 3) Дөрвөлжин чулуун хашлагын хойд талын ханын гадна талаас нэг шавар эдлэл олдсон. Шавраар хийж сайтар шатаасан. Нэг талдаа бариул хийх углуурга нүх гаргасан. Ямар нэг зүйл нухах нүдүүрийн толгой байж магадгүй. Хэмжээ нь 6 см голчтой, хонхор хэсгийн голч 2 см, зузаан нь 3.4 см. 4) Төмөр эдлэлийн хэсэг, ширмэн цөнгийн хагархайнууд. 5) Шаазан аяганы ёроол хэсэг. Дотор талдаа шар ногоон паалантай. Ёроолын голч 7 см. 6) Шаазан, шавар савны хэлтэрхий олдсон.

6. Дугшихын балгас – Сорилтын малтлага-6

Дугшихын худгаас зүүн зүгт, сорилтын малтлага 3-аас баруун урагш 166 м зайтай, шороон замын урд талд байгаа бүлэг сууцны хойд захад оршино. Байршил: 48 U 0521757, UTM 4908066, далайн түвшнээс дээш 1232 м өндөр. Газрын өнгөн хөрсөн дээр чулуугаар дөрвөлжлөн өрсөн, 200 см урт, 75 см өргөн, нягт дараастай, дараасын баруун урд буюу урд захад бусдаас том ганц чулууг хөшөө маягтай



Зураг 3. Дугшихын балгас. Сорилтын малтлага 5. Сууцны шал ба ханзан халаалтын систем

тавьсан байв. Өнгөн хөрсний цэвэрлэгээний явцад 15 см гүнээс вааран савны ёроол, цагаан паалантай шаазангийн амсрын хэсэг олдов. Чулуун дараас нь ганцхан үе, дараасын төв хэсгээс 36 см гүнд бог малын ясны жижиг хэсгүүд гарч, түүний дороос 40 см гүнд байгалийн ул хөрс гарсан. Оршуулгын нүх болон хүний яс байхгүй.

Хэлэлцүүлэг

МУИС-ийн Нүүдэлчдийн археологийн хүрээлэн, Японы Шова Эмэгтэйчүүдийн Их Сургуулийн хамтарсан судалгааны анги 2024 онд Дугшихын балгасын эртний хотын дэвсгэрт хайгуул хийж, нийт 6 газар сорилтын малтлага гүйцэтгэж, түүвэр олдвор цуглуулав. Дугшихын балгас нь гадуураа нэгдсэн хамгаалалтын хэрэм далан байхгүй. Хоорондоо дов толгодоор тусгаарлагдсан гурван хэсгээс бүрдэж байсан бололтой. Хэсэг тус бүрдээ дундуураа гарсан гудамтай, хоёр талаар нь эгнүүлэн барьсан жижиг барилгуудтай байжээ. Дээврийн ваарны хагархай, барилгын чимэглэл, шатаасан тоосго олдохгүй байхаас үзвэл мод шавраар хийсэн тун энгийн хийцтэй барилгууд байсан бололтой. Энэ барилгууд хэмжээгээр жижиг бөгөөд ханзан халаалтын системтэй байсан нь сорилтын малтлага 3, 5-аас тодорхой болов. Барилгын гадна талаар хашаа, малын саравч байсан мэт бөгөөд хашаа хороо байсны ором

халцархай газар, цагаан цайвар өнгийн чулуугаар газар эгнүүлэн нөмөрлөж хашсан өрлөгийн суурь үлдсэнээс мэдэгдэнэ. Дугшихын балгасанд бидний малтан судалсан, цагаан цайвар өнгийн чулуугаар өрсөн жижиг байгууламжуудаас булш оршуулгатай холбоотой баримт илэрсэнгүй.

Дугшихын балгасанд 2024 онд бидний хийсэн сорилтын гурван малтлагаас илэрсэн малын ясны дээжийг Япон улсын Accelerator Analysis Laboratory Co., Ltd. компанийн ^{14}C лабораторид илгээн үнэмлэхүй он цагийг тогтоолгоход 1270-1370 оны хооронд буюу Монголын Их Юань улсын үед холбогдох нь тодорхой болов (Erdenebat *et al.* 2025: 40-41: Хүснэгт 1-2, Зураг 4).

Түүвэр олдворын хувьд Дугшихын балгас нь нэлээд баялаг юм. Импортын хятад ваар шаазангийн хагархай болон орон нутгийн шавар керамикийн хэлтэрхий элбэг олдоно. Хятад шаазангийн хувьд динчжоу, цычжоу, цзюнь, рү-яо, чинбай, хөх хуартай ченхуа болон жиаотай зэрэг XIII-XIV зууны Монголын нийслэл Хархорум хотоос олддог хятад шаазангийн бүх төрөл Дугшихын балгасаас олдож байна. Бид хожим Дугшихын балгасын хятад шаазангийн тухай тусгай өгүүлэл нийтлэхээр бэлтгэж байна.

Дугшихын балгасанд амьдарч байсан хүн амын гар үйлдвэрлэлийн үйл ажиллагааг тэдний үлдээж хоцроосон эд өлгийн биет зүйлүүдээс үндэслэн нэлээд өргөн хүрээтэй байсан гэж хэлж болно. Дугшихын

Хүснэгт 1. Дугшихын балгас. Радио идэвхт нүүрстөрөгчийн он цаг тогтоох шинжилгээний үр дүн ($\delta^{13}\text{C}$, 14C он цаг [Либбигийн нас], pMC, IAA бүртгэлийн дугаар: #C984)

Лабораторийн хэмжилтийн дугаар	Дээжийн хаяг	CoEx	$\delta^{13}\text{C}$ (‰) (AMS)	$\delta^{13}\text{C}$ залруулгатай	
				Libby Age (yrBP)	pMC (%)
IAAA-241774	Өмнөговь, Цогт-Овоо, Дугшихын балгас, Сорилтын малтлага 3, Малын яс	CoEx	-15.91±0.35	590±20	92.86±0.27
IAAA-241775	Өмнөговь, Цогт-Овоо, Дугшихын балгас, Сорилтын малтлага 5, Малын яс	CoEx	-18.38±0.42	680±20	91.88±0.27
IAAA-241776	Өмнөговь, Цогт-Овоо, Дугшихын балгас, Сорилтын малтлага 6, Малын яс	CoEx	-13.63±0.37	580±20	93.03±0.27

Хүснэгт 2. Дугшихын балгас. C14 он цаг тогтоох шинжилгээний үр дүн



Лабораторийн хэмжилтийн дугаар	Календарийн он цагийн шалгалт тохируулга (yrBP)	Шалгалт тохируулгын нөхцөл	1σ Календарийн он цагийн хязгаар	2σ Календарийн он цагийн хязгаар
IAAA-241774	594±23	OxCal v4.4 IntCal20	1320calAD - 1359calAD (55.8%) 1390calAD - 1399calAD (12.4%)	1305calAD - 1365calAD (73.2%) 1383calAD - 1406calAD (22.3%)
IAAA-241775	680±23	OxCal v4.4 IntCal20	1283calAD - 1301calAD (50.1%) 1370calAD - 1378calAD (18.2%)	1276calAD - 1313calAD (61.3%) 1361calAD - 1388calAD (34.2%)
IAAA-241776	580±23	OxCal v4.4	1324calAD - 1354calAD (51.9%) 1393calAD - 1403calAD (16.4%)	1308calAD - 1363calAD (67.1%) 1386calAD - 1413calAD (28.4%)

балгасын түүвэр олдворын дотор, чанар муутай ширмэн цөнгийн хагархай, төмөр хадаас, ширмэн тогоо, төмөр эдлэлийн хаягдал, зэсийн хайлшаар юм хийж байсны үлдэц, төмрийн бэлдцийн хугархай элбэг олдож байгаа нь энд төмөрлөг эд зүйл, зэс, хүрлээр юм хийдэг дархны газар ажиллаж байсныг харуулах бололтой (Зураг 5, 6).

Төмрийн үйлдвэрлэл гэдэг дан ганц бэлэн бүтээгдэхүүнээр хэмжиж ойлгох зүйл биш. Энэ бол төмрийн хүдэр бүхий орд газар хайж олох, түүнийг олборлох, зөөж тээвэрлэх, хайлуулж боловсруулах, төмөр гаргаж авах, төмрийн эд зүйл хийх гэсэн бүхэл бүтэн цогц үйл ажиллагаа байдаг (Ишцэрэн

2024: 145). Монголын дундад зууны хот сууриныг археологийн талаар судлах явцад гар урчууд ашиглаж байсан төмрийн бэлдэц хэмээх зүйл нэлээд олджээ (Мөнхбаяр, Пүүл, Аренс 2012: 290; Reichert 2020: 103-110). Төмрийн бэлдэц (ingot) гэдэг нь баяжуулсан төмрийг цутгуурын хэвд хийсэн, ойролцоогоор 1 см өргөн, 5 см урт хэмжээтэй, саваа хэлбэрийн цутгамал гулдмай юм. Дугшихын балгасаас олдсон, харьцангуй бүтэн хадгалагдсан төмрийн бэлдэц 4,8 см урт, хэвэнд цутгасан, гонзгой дөрвөлжин саваа хэлбэртэй. Дөрвөн тал нь тус бүр 1 см зузаан хэмжээтэй. Хүндийн жин 27,8 г хэмжээтэй байна.

Төмрийн бэлдцийг зөөн төмөр зэвсэг үйлдвэрлэдэг



Зураг 4. Дугшихын балгас. Календарийн жилээр тохируулсан он цагийн график

тогтолцоо НТӨ III зуунаас Зүүн Азид өргөн тархсан бөгөөд түүхий эд нийлүүлэлтийн ердийн арга байжээ (Ширайши 2012: 60). Японы мэргэжилтэн Масами Осавагийн хийсэн судалгаанаас үзвэл, XIII-XIV зууны үед Шаньдун, Ганьсу мужид хийсэн төмрийн бэлдцийг Монголын Аваргын балгас хүртэл зөөвөрлөж байсан ажээ. Аваргын балгасаас олдсон төмрийн бэлдцэд хийсэн бүтцийн задлан шинжилгээний дүнд, түүнийг Хятадын Шаньдун мужийн Жинлин төмрийн уурхай, Ганьсу мужийн Мазонг Шан төмөрт уулын төмрийн хүдрээс гаргаж авсан болохыг тодорхойлжээ (Osawa 2005: 54-55, 61; Osawa 2013: 141). Түүнчлэн Монголын нийслэл Хархорум, Шаазан хотоос олдсон төмрийн бэлдцийн найрлага Аваргын балгасаас гарсан төмрийн бэлдцтэй адилхан гарсан байна (Osawa 2013: 225-228). Солонгосын судлаач Пак Жаншиг Хархорум хотын туриас илэрсэн 26 ширхэг олдворт бүтцийн задлан шинжилгээ хийхэд нүүрстөрөгчийн агуулга ихтэй, цутгамал төмрийг ашиглаж байсан гэх судалгааны үр дүн гарсан нь Японы эрдэмтдийн судалгааны үр дүнтэй таарч байгаа юм (Park, Reichert 2015: 49-60).

Дундад зууны үед төмөр баяжуулах үйл ажиллагаа их төлөв төмрийн уурхайн ойр хийгддэг байжээ. Төмөртэй уулын ойролцоо төмөр хайлуулах газар

байгуулж, төмрийн хүдрээс түүхий эд гаргаж авдаг байсан. Түүхий эдээр таваар хийхийн тулд урт дөрвөлжин хэлбэртэй, өргөн нь ойролцоогоор 1 см, урт нь 5 см төмрийн бэлдцийг хэвэнд цутган хийж бэлтгэдэг. Тэдгээр бэлдцийг төмрийн хүдрийн уурхайн ойролцоо хайлуулан баяжуулан гаргаж аваад нэг адил хэвд цутган их хэмжээгээр үйлдвэрлэж байжээ. Овор хэмжээ бага тэр бэлдцийг морь, үхэр тэргээр ачиж алс хол зөөвөрлөн үйлдвэрлэлийн газар аваачна. Бэлэн төмрийн бэлдцийг хот суурин дархны газар шууд хайлуулж төрөл бүрийн бүтээгдэхүүн хийнэ. Монгол нутагт буй дундад зууны хот суурингуудаас олдсон төмрийн бэлдэц нарийн саваа хэлбэртэй байгаа нь дархны газарт бага хэмд хурдан хайлуулж харвуулын сумны зэв, хадаас зэрэг эд зүйлс хийхэд маш тохиромжтой. Түүнээс гадна овор бага, жижиг хэмжээтэй учир аян дайнд авч яваад хэрэгцээтэй үедээ эд зүйл хийхэд тохиромжтой байжээ (Ишцэрэн 2024: 191).

Монголын эзэнт гүрний үеэс өмнөх үеийн дурсгалт газруудаас олдсон төмөрлөг эд зүйлсэд хийсэн задлан шинжилгээний үр дүнгээс үзвэл хуучин ширмэн тогоо, төмөр зоос зэргийг дахин боловсруулах аргаар хийсэн тохиолдол нэлээд байжээ. Хуучин төмрийг дахин хайлуулж ашиглахад гарах илүүдэл химийн элемент ихээр агуулсан хольц ихтэй хэврэг болдог байв. Харин Монголын эзэнт гүрний үеэс сайн чанартай төмрийн бэлдэц үйлдвэрлэлд нэвтэрснээр дархны газрууд тогтвортой түүхий эдээр хангагдах боломж нээгдсэн байна (Ишцэрэн 2024: 208-209).

Өмнөд Сүн улсын “Жианянаас эхэлсэн он цагийн товчоон” хэмээх түүхэнд 1139 оны үеийн нэгэн хэрэг явдлыг тэмдэглэхдээ: “Татар бол Алтан улсын баруун хойд хэсгээр нутагладаг ба Хятадтай ойр оршихыг нь “Цагаан татар” (боловсон), холыг нь “Хар татар” (бүдүүлэг) хэмээн нэрлэдэг. Тэнд төмрийн үйлдвэрлэл

байхгүй учир сумны зэвийг ясаар хийдэг. Хятан улсын хар зах дээр татарууд худалдаа арилжаа хийдэг боловч тэдэнтэй төмрийн худалдаа хийхийг хатуу чанга хориглосон байжээ. Алтан улсын үе хүрэхэд энэ худалдааны хориг нь ихэд суларч Ли Юү хэмээх хятад захирагчийн нутагт зоосон мөнгө хүрэлцэхгүй болсон. Шалтгаан нь Шаньси, Шэньси мужид хэрэглэж байсан төмөр зоос их хэмжээгээр Татар руу зөөгддөгтэй холбоотой. Тэр үеэс татарууд төмөр боловсруулж их хэмжээний төмөр зэвсэг үйлдвэрлэх болжээ” гэж бичсэн байна (Ширайши 2012: 54). Энэхүү сурвалжийн мэдээнд гарч байгаа “төмөр зоос” Дугшихын балгасанд хийсэн хайгуулаар ганц ширхэг олдсон (Зураг 7). Уг төмөр зоос нь дээрээ ямар нэгэн үсэг бичиг байхгүй. Дундаа дөрвөлжин нүхтэй. Голч 3,3 см, зузаан 0,2 см, хүндийн жин 8,66 г болно. Магадгүй, Өмнөд Сүн улсын бичигт гарч байгаа, Ляо улсын үеэс Монголын тал нутаг руу түүхий эд болгох зорилгоор зөөж байсан төмөр зоос байж мэдэх юм.

Зоос мөнгө бол Монголын дундад зууны археологийн нэгэн сонирхолтой судлагдахуун бөгөөд нэг талаас төлбөрийн хэрэгсэл буюу нүүдэлчдийн дунд мөнгөн гүйлгээ тогтож хэвшсэн түүхийн гэрч болдог. Гэвч нүүдэлчдийн дунд арилжаа наймаа нь эрт үеэс зоос мөнгөөр худалдан авах гэхээс илүүтэй бэлэн бүтээгдэхүүнийг солилцох хэлбэрээр явагдаж байжээ. Үүний нэгэн гэрч нь Монголын эрт, дундад үеийн нүүдэлчдийн булшнаас зоос мөнгө ерөнхийдөө тун бага олддог явдал юм. Түүхч Д.Гонгор гуай бичихдээ: “Юань улсын үед Хархорум зэрэг төв суурин газрын худалдаанд Хятад, Дундад Азийн мөнгөн тэмдэгт, мөн Юань улсын үед монгол хаадын удаа дараа дармалан гаргасан цаасан мөнгийг хэрэглэж байсан боловч тэр нь зөвхөн хааны орд, хот суурин газрын хүрээгээр

хязгаарлагдаж Монголын жирийн нүүдэлчин малчдын дунд дэлгэрэл олоогүй, тэд түүнийг олигтой хэрэгсдэггүй ч байжээ. Харин “Нууц Товчоо” зэрэг сурвалж бичигт дурдсан “сүхэс” мөнгийг хэрэглэж байсан болзошгүй. Юун боловч гадаад худалдаанд мөнгө зоос рольтой асан боловч дотоод худалдаа нь арилжааны шинжтэй байжээ” гэж дүгнэсэн байдаг (Гонгор 1978: 370).

Хархорум хотод 1949 онд Монгол-Зөвлөлтийн хамтарсан шинжилгээний ангийн хийсэн малтлагаар соёлт давхрагаас 230 зоос олджээ. Түүний дотор Тан (618-907), Умард Сүн (960-1127), Алтан улс (1115-1234), Өмнөд Сүн (1127-1279), Юань (1271-1368) үеийн зоос байсан байна. Дээр үеийн зооснууд нь Хархорумын эртний түүхийг харуулж байна гэхээс илүүтэй, тэдгээр зооснууд удаан хугацааны турш төлбөрийн хэрэгслийн үүрэг гүйцэтгэж байсантай холбоотой гэж Оросын археологичид үзжээ. Мөнгөн гүйлгээний өсөн нэмэгдлийн хувьд, дээд үе давхрагаас олдсон зооснууд нь доод үе давхрагаас гарснаасаа тооны хувьд хавьгүй олон байсан байна. Мөнгөн гүйлгээ нь үндсэндээ мусульманчууд, хятадууд зэрэг харийнхны гарт байсан байж болох юм. Монголчууд болер нь дассан зуршлаараа барааг бараагаар солилцох дуртай байв. Юань улсын үеийн зоос харьцангуй цөөн олдсоныг Юань улсын үед Хархорумын ач холбогдол буурсантай холбоотой гэж Л.А.Евтюхова тайлбарлан бичсэн байдаг (Евтюхова 1965: 185-187).

Монгол-Германы археологичдын 2000-2005 оны судалгаагаар зөвхөн Хархорум хотын төв орчмоос 300 гаруй хятад зоос олдсоны ихэнх нь Умард Сүн улсын зоос (960-1127) байжээ (Эрдэнэбат 2018: 281). Энэ байдал нь Дундговь аймгийн Сайхан-Овоо сумын нутагт орших Шаазан хот зэрэг Монголын дундад



Зураг 5. Дугшихын балгас. Төмрийн бэлдэц



Зураг 6. Дугшихын балгас. Зэс, хүрлээр юм хийж байсан үлдэгдэл





зууны үеийн хотуудын хувьд мөн адилхан байгаа юм (Rogers, Erdenebat, Gallon 2005). Тухайлбал, Шаазан хотоос 2001 онд зохиогчийн түүвэрлэж цуглуулсан 12 зоосны 8 нь Умард Сүн, 1 нь Юань улсын үеийн зоос бөгөөд 3 нь хадгалалтын байдлаас он цагийг тогтоож чадаагүй (Хүснэгт 3).











Дугшихын балгасанд 2024 онд цөөн хоног ажиллах хугацаанд бүтэн, хагархай нийлээд нийт 37 ширхэг зоос түүвэрлэсний дийлэнх нь буюу 20 ширхэг нь Умард Сүн улсын, 8 ширхэг нь Зүрчидийн Алтан улсын, 4 ширхэг нь Тан улсын үеийн хятад зоос байна (Хүснэгт 4). Хэрэв нүүдэлчдийн дунд арилжаа наймаа барааг бараагаар солилцох хэлбэрээр илүүтэй явагдаж байсан, Монголын жирийн нүүдэлчин малчид зоос мөнгийг олигтой хэрэгсдэг ч үгүй байсан юм бол Монголын дундад зууны хотуудаас яагаад өмнөх цаг үеийн, тухайлбал Умард Сүн улсын хятад зоос хамгийн элбэг олддог юм бол? гэсэн асуулт тавигдана.

Энэ асуултанд тодорхой хэмжээгээр хариулт олоход, XIII-XIV зууны үед Юань улс Японтой худалдаа хийж байсан түүхийг эдийн засгийн үүднээс судалсан Японы эрдэмтэн, профессор Иинума Кенжи

нарын судалгааг харьцуулан авч үзэхэд сонирхолтой юм. Их Юань гүрний түүхийг Япон талаас судалсан судалгааны өгүүлэлд “Юань гүрний 14 дүгээр онд (1277) Их Юань гүрэн Япон руу довтолгоо ид хийж байсан үеийг үл харгалзан Япон худалдаачдыг алт авчран зэс зоос худалдан авахыг зөвшөөрч байсан гэж бичсэн байна. Энэ нь Япон худалдаачдын худалдааг өргөжүүлэх гэхээс илүүтэй Өмнөд Сүн улсыг эдийн засгийн хувьд сүйрүүлэх төлөвлөгөө хэмээн харж болно. Сүн улсын үеэс эхлэн Япон улс Хятадаас Сүн улсын зэс зоосыг их хэмжээгээр импортолдог байсан ба үүнийгээ Камакурагийн үед Японы мөнгөн тэмдэгт болгон ашиглаж байжээ. Яг үнэндээ энэ зоос нь өөр нэгэн хэрэглээтэй байсан. Ер нь бол анхнаасаа л ийм зорилготой орж ирсэн гэж хэлж болно. Бөмбүгийн их сургуульд масс спектрометр бүхий хар тугалганы изотопын харьцааны аргаар хар тугалганы эх үүсвэрийг тодорхойлоход хэрэглэж, улмаар Сүн улсын зоос, Японы зэс эдлэлд дүн шинжилгээ хийх, түүхэн баримт бичгүүдийг судлахад ашиглажээ. Үүний үр дүнд Камакура нь Их Буддаг Сүн улсын зэс зоосоор урласан бөгөөд дундад зууны үеийн сүм хийдийн

Хүснэгт 3. Шаазан хот – Зоосны түүвэр олдворууд

№	Нэр	Материал, тэмдэглэл	Он цаг	Голч	Зузаан	Жин	Зоосны дардас (нүүр ба ар талаас)
1	熙寧元寶-xi ning yuan bao (1068-1077)	Зэсийн хайлш	Умард Сүн	2.3 см	0.15 см	3.79 г	  2 cm
2	熙寧元寶-xi ning yuan bao (1068-1077)	Зэсийн хайлш	Умард Сүн	2.45 см	0.1 см	3.74 г	  2 cm
3	熙寧元寶-xi ning yuan bao (1068-1077)	Зэсийн хайлш	Умард Сүн	2.4 см	0.15 см	3.65 г	  2 cm
4	元寶-yuan bao	Зэсийн хайлш, цоолж нүхэлсэн		2.35 см	0.1 см	3.18 г	  2 cm
5	熙寧元寶-xi ning yuan bao (1068-1077)	Зэсийн хайлш	Умард Сүн	2.3 см	0.1 см	2.90 г	  2 cm
6	熙寧元寶-xi ning yuan bao (1068-1077)	Зэсийн хайлш	Умард Сүн	2.25 см	0.15 см	3.18 г	  2 cm

7	“元豐通寶- yuan feng tong bao” (1078-1085)	Зэсийн хайлш	Умард Сүн	2.8 см	0.12 см	6.2 г	 
8	元祐通寶 Yuan you tong bao (1086-1094)	Зэсийн хайлш		2.4 см	0.12 см	3.95 г	 
9	至元通寶 Zhi yuan tong bao (1285-)	Зэсийн хайлш	Юань улс	2.45 см	0.1 см	3.12 г	 
10	至道元寶 Zhi dao yuan bao (995-998)	Зэсийн хайлш	Умард Сүн	2.45 см	0.1 см	3.57 г	 
11		Зэсийн хайлш		2.5 см	0.1 см	2.14 г	 
12	天聖元寶- tian sheng yuan bao 1023-?	Зэсийн хайлш	Умард Сүн	2.45 см	0.15 см	3.66 г	 



Зураг 7. Дугшихын балгас. Төмөр зоос

хонхыг Сүн улсын зэс зоосоор цутгаж байсан нь тогтоогдсон байна (Кенжи 2025: 133).

Ийнхүү Японд Камакурагийн үед Сүн улсын зэс зоос нь мөнгөн тэмдэгт төдийгүй зэс бүтээгдэхүүний чухал түүхий эд байжээ. Тухайн үед Сүн улсын дотоодод ч гэсэн зэсийн түүхий эдийг хот руу оруулахыг хязгаарлаж, экспортлохыг хориглосноос болж Хятадын хувийн хэвслүүд төдийгүй мужийн жоу сянд хүртэл зэс зоосыг түүхий эд болгон ашиглаж байсан ажээ.

Энэ бүхнийг Монголын дундад зууны хотуудаас өмнөх цаг үеийн, ялангуяа Умард Сүн улсын зоос их хэмжээгээр олддог явдалтай харьцуулан бодвол, тухайн цаг үеийн нэгэн адил монголчууд бас Сүн улсын зэс зоосыг бүтээгдэхүүн үйлдвэрлэх түүхий эд болгон ашиглаж байсныг үгүйсгэх аргагүй юм. Дараагийн судалгааны түвшинд Дугшихын балгасаас олдсон төмрийн бэлдэц, төмөр болон зэс зоосыг, төмрийн болон зэс, хүрлийн дархны газрын бүтээгдэхүүнтэй харьцуулан бүтэц найрлагын шинжилгээ хийх чухал байна.

Евразийн эртний хүрэл эдлэлийн химийн найрлагыг Монгол улсын Дундговь аймгийн Бага газрын чулуунаас олдсон Хүннүгийн үеийн хүрэл эдлэлүүдийн жишээн дээр харьцуулсан судалгаанаас үзэхэд, бүр Хүннүгийн үеэс Цинь, Хань улсад үйлдвэрлэсэн хүрэл эдлэлийг Монголын говийн бүсийн үйлдвэрлэгчид цуглуулж, дахин хайлуулж, орон нутгийн хүрэл эдлэлийг бүтээхэд ашигладаг байжээ. Хятадын эртний болон зүүн хойд Евразийн хүрлийн хооронд тод ялгаа байдаг бөгөөд зэсийн хайлш дахь хүнцэл, хар тугалганы агууламж юм. Монгол, Өмнөд Сибирээс гаралтай хүрэлд хүнцэл их хэмжээгээр агуулагддаг, хайлшийн гол элемент байжээ. Гэтэл Хятадын хүрэлд хүнцэл нь хэзээ ч гол хайлшийн элемент биш бөгөөд зөвхөн зэсийн хүдэрт


санамсаргүйгээр нэмсэн элементийн хувьд л оршдог. Харин хар тугалга ашиглах хандлага эсрэгээрээ, Хятадын хүрэл эдлэлд байдаг хайлшийн гол элемент байжээ. Хятадын хүрэлд ихэвчлэн цагаан тугалга, хар тугалга зэргээс бүрдэх нийт хайлшийн элементийн эзлэх хувь ерөнхийдөө 15% ба түүнээс дээш байдаг бол Евразийн тал хээр нутгийн хүрэл дэх нийт хайлшийн агууламж хүрлийн сүүлч ба төмрийн эхэн үед 10% ба түүнээс бага байсан байна (Park, Honeychurch, Amartuvshin 2011: 805-817).





Монголын эзэнт гүрний үед асар өргөн уудам нутаг дэвсгэрийг эзэмшин захирахын тулд тэдгээрийг хооронд холбосон зам харилцаа, өртөө улааны бүхэл бүтэн тогтолцоог бий болгох шаардлагатай болжээ. Өгэдэй хааны үеэс зам харилцаа, холбоо саадгүй явагдах, эд барааг саадгүй тээвэрлэхийн тул өртөө улааны албыг өргөтгөн шинэчилсний нэлээд хэсэг нь Хятадаас Хархорум руу чиглэж байсан бөгөөд “баян зам”, “нарийн зам” гэдэг хоёр янзын өртөөний сүлжээ байсан байна. Хубилайн үеэс энэхүү зам харгуйг улам сайжруулж, өртөө бүрийн хооронд гурван бээр тутамд дөч орчим орон сууцтай суурин гацаа байгуулсан аж. Марко Пологийн тэмдэглэснээр, айл амьтан үгүй хотоос алс бөглүү орших газруудад өртөө улаа байгуулж, дөрвөн зуун морь болон хэрэгцээтэй бүхнээр хангахыг зарлигдсан бөгөөд мөн өртөөнд суух албан хаагчид ба газар тариалан эрхэлж тус газарт үйлчлэх хүмүүсийг томилсон байна (Марко Поло 2019: 100-101).






Юань улсын үед Давааны арын мужид нэвтрэх тэргэн зам, морин зам, нарийн зам гэх нийт 119 өртөө байгуулж, эзэнт гүрний нийслэл Хаанбалык, дээд нийслэл Шанду, Их Монгол улсын хуучин нийслэл Хархорумыг хэд хэдэн шугамаар холбосон байна. Тэдгээрээс морин зам буюу дунд зам нь Шандугаас баруун тийш Бор хотыг дамжин Синхэ, Датун чөлгөөгийн ар хязгаараар өнгөрөөд, Фэнчжоугийн баруун хойд биеийн Дяньчэншу хавцлаар дамжин Далан хар уулнаас гарч, Циньчжоу, Сяцзинь зэрэг газрыг өнгөрч их говийн элсэнд орж, Давааны арын мужийн өртөө замтай нийлэн Хархорумд хүрдэг байжээ. Зарим судлаачдын үзэж буйгаар, энэ зам нь одоогийн Монгол улсын Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Ханги Мандал боомт орчмоор орж говийн баянбүрд дамжин Өмнөговь аймгийн Ханбогд, Цогтцэций сумын араар гарч, тэндээс Дэлгэрхангай уул, түүнээс баруун тийш Онгийн голыг өгсөн Орхоны хөндий рүү орж Хархорум хотод хүрэхээр ерөнхий чиг нь таарч байгаа ажээ (Энхтөр 2025: 37).


Энэ чиглэлийн дагуу Их Монголын эзэнт гүрэн, Юань улсын үед холбогдох Тахилын усны суурин (Пэрлээ 1961: 92-93), Дүүдий тээг (Эрдэнэболд, Уртнасан 2024: 195-191), Шаазан хот, Шаазан толгой, Шаазант, Мазар, Зоост (Баяр 2003: 49-54) зэрэг хотууд

Хүснэгт 4: Дугшихын балгас. Зоосны түүвэр олдворууд

№	Нэр	Материал	Цаг үе ба тэмдэглэл	Голч	Зузаан	Жин	Зоосны дардас (нүүр ба ар талаас)
1	皇宋通寶 Huang song tong bao (1039-1054)	Зэсийн хайлш	Умард Сүн	2.5 см	0.15 см	3.95 г	 2 cm
2	皇宋通寶 Huang song tong bao (1039-1054)	Зэсийн хайлш	Умард Сүн	2.55 см	0.15 см	3.68 г	 2 cm
3	元祐通寶 Yuan you tong bao (1086-1094)	Зэсийн хайлш	Умард Сүн	2.45 см	0.1 см	4.03 г	 2 cm
4	元符通寶 Yuan fu tong bao (1098-1100)?	Зэсийн хайлш	Умард Сүн	2.5 см	0.15 см	3.36 г	 2 cm
5	祥符元寶 Xiang fu yuan bao (1008-1016)	Зэсийн хайлш	Умард Сүн	2.6 см	0.2 см	4.82 г	 2 cm
6	開元通寶 Kai yuan tong bao (621-907)	Зэсийн хайлш	Тан улс	2.5 см	0.15 см	3.31 г	 2 cm
7	中華民國 五年 Zhong hua ming guo wu nian (1916)	Зэсийн хайлш	Дундад Иргэн улс (1912-1949?)	2.6 см	0.2 см	6.48 г	 2 cm

8	熙寧元寶 Xing ning yuan bao (1068- 1077)	Зэсийн хайлш	Умард Сүн	2.4 см	0.1 см	3.74 г	 
9	嘉祐通寶 Jia you tong bao (1056- 1063)	Зэсийн хайлш	Умард Сүн	2.5 см	0.1 см	3.13 г	 
10	皇宋通寶 Huang song tong bao (1039- 1054)	Зэсийн хайлш	Умард Сүн Ар талдаа сартай	2.5 см	0.15 см	4.53 г	 
11	開元通寶 Kai yuan tong bao (621-907)	Зэсийн хайлш	Тан улс	2.4 см	0.1 см	3.46 г	 
12	至zhi	Зэсийн хайлш	?	2.5 см	0.2 см	2.29 г	 
13	大定通寶 Da ding tong bao (1178- 1188)	Зэсийн хайлш	Алтан улс	?	0.1 см	1.61 г	 
14	至道元寶 Zhi dao yuan bao (995-998)	Зэсийн хайлш	Умард Сүн	2.5 см	0.15 см	3.83 г	 

15	景德元寶 Jing de yuan bao (1004- 1007)	Зэсийн хайлш	Умард Сүн	2.5 см	0.15 см	4.51 г	 
16	元符通寶 Yuan fu tong bao (1098- 1100)	Зэсийн хайлш	Умард Сүн	2.4 см	0.15 см	4.21 г	 
17	皇宋通寶? Huang song tong bao (1039- 1054)	Зэсийн хайлш	Умард Сүн	2.5 см	0.1 см	3.81 г	 
18	[熙]寧重 [寶] Xing ning yuan bao (1068- 1077)	Зэсийн хайлш	Умард Сүн	3 см	0.15 см	2.91 г	 
19	元[符通]寶 Yuan fu tong bao (1098- 1100)	Зэсийн хайлш	Умард Сүн	?	0.1 см	1.62 г	 
20	寶 bao	Зэсийн хайлш		?	0.1 см	1.06 г	 
21	祥符元寶 Xiang fu yuan bao (1008- 1016)	Зэсийн хайлш	Умард Сүн	2.5 см	0.21 см	7.21 г	 

22	大定通寶 Da ding tong bao (1178- 1188)	Зэсийн хайлш	Алтан улс	2.6 см	0.15 см	3.13 г	 2 cm
23	咸平元寶 Xian ping yuan bao (998-1003)	Зэсийн хайлш	Умард Сүн	2.5 см	0.15 см	3.15 г	 2 cm
24	天禧通寶 Tian xi tong bao (1017- 1021)	Зэсийн хайлш	Умард Сүн	2.5 см	0.15 см	3.67 г	 2 cm
25	熙寧元寶 Xing ning yuan bao (1068- 1077)	Зэсийн хайлш	Умард Сүн	2.5 см	0.2 см	4.26 г	 2 cm
26	大定通寶 Da ding tong bao (1178- 1188)	Зэсийн хайлш	Алтан улс	2.5 см	0.1 см	2.87 г	 2 cm
27	開元通寶 Kai yuan tong bao (621-907)	Зэсийн хайлш	Тан улс	2.4 см	0.1 см	3.09 г	 2 cm
28	開元通[寶] Kai yuan tong bao (621-907)	Зэсийн хайлш	Тан улс	2.4 см	0.2 см	2.99 г	 2 cm
29	...元寶 yuan bao	Зэсийн хайлш		2.5 см	0.1 см	1.78 г	 2 cm

30	Chinese coin	Зэсийн хайлш	?	0.1 см	1.46 г	
						
31	绍圣元寶 Shao sheng yuan bao (1094-1098?)	Зэсийн хайлш	Умард Сүн	2.45 см	0.2 см 3.97 г	
						
32	元祐通寶 Yuan you tong bao (1086-1094)	Зэсийн хайлш	Умард Сүн	3 см	0.2 см 6.96 г	
						
33	Төмөр зоос	Төмөр	Умард Сүн эсвэл Ляо ? Үсэггүй	3.3 см	0.2 см 8.66 г	
						
34	治平元寶 zhi ping yuan bao (1064-1067)	Зэсийн хайлш		2.4 см	0.1 см 3.99 г	
						
35	...寶 bao	Зэсийн хайлш	?	0.15 см	1.79 г	
						
36	Хятад зоос	Зэсийн хайлш	?	0.1 см	1.46 г	
						
37	Хятад зоос	Зэсийн хайлш	?	0.2 см	1.47 г	
						

байгаа бөгөөд Дугшихын балгас ч гэсэн энэхүү морин замын нэгэн өртөө байсан байж болохоор байна. Эдгээр суурингууд нь Монголын говь хээрийн бүсийн ундарга сайтай худаг, баянбүрд бүхий булгийн дэргэд орших бөгөөд гадуураа нийт суурингийн талбайг хамарсан хэрэм бэхлэлтгүй, дундуураа гудамж бүхий олон тооны том жижиг барилгаас бүрдсэн, өвөл зунгүй хүн сууж болох ханзан халаалт бүхий байшингуудтай, аж ахуйн хашаа хороо, нөөцийн том шавар сав, хятад шаазангийн хагархай, тэрэгний цөн, зоос мөнгө, төмөр зэсээр юм дархалж сэлбэж байсан ул мөр элбэг олдогоороо нийтлэг юм.

Товч дүгнэлт

Иймээс Дугшихын балгас нь Монголын эзэнт гүрэн болон түүний дараах үед Хархорум хот руу аян жин тээдэг худалдааны замын нэг чухал зангилаа байсан гэх нутгийн ардын домог яриа үнэний хувьтай байна. Түүнээс гадна Дугшихын балгасаас бүр хожуу цаг үеийн хятад шаазан, ваар савны хагархай, зоос ч олдож байгаа. Энэ байдлаас үзэхэд хуучин жингийн замыг Монголын эзэнт гүрнээс хойш ч удаан хугацаанд ашиглаж байсан гэж үзэж болох юм. Гэвч энэ бүхнийг лавшруулан шалгахад илүү удаан хугацаагаар ажиллаж олон гэрч баримтыг олох, судлах хэрэгтэй нь мэдээж.

Abstract

Dugshikhyn Balgasun

Ulbayar Erdenebat

The radiocarbon samples collected from the Dugshikhyn Balgas site were sent to Japan and returned dates between 1270 and 1370 AD and relate to the Yuan Dynasty. The article discusses iron castes as well as iron and copper coins in relation to production processes. Dugshikhyn Balgasun was an important center that connected Kharakhorum with other destinations during and after the Mongol Empire.

Keywords: Dugshikhyn Balgasun, Mongol Empire, Yuan Dynasty, settlement archaeology

Ном зүй

Баяр, Д. (2003). Шаазан хотыг сурвалжилсан нь. *Scientific Journal of National University of Mongolia*. Vol. 210 (19). Series : Archaeology, Anthropology and Ethnology. УБ., 49-54.

Гонгор, Д. (1978) Халх товчоон. II боть: Халх

монголчуудын нийгэм-эдийн засгийн байгуулал (XI-XVII зуун). УБ.

Евтюхова, Л.А. (1965). Монеты из культурного слоя Кара-Корума. Древнемонгольские города. Под редакцией С.В.Киселева. Москва, 183-187.

Ишцэрэн Л. (2024). Төмөр ба нүүдэлчид: Монголын нүүдэлчин төрт улсуудын төмөр үйлдвэрлэл (НТӨ II-НТХIII). УБ.

Кенжи, И. (2025). Монголын довтолгоо ба Япон-Монголын харилцаа. “Хубилай хааны Япон улсад хийсэн довтолгооны дараах 750 жил”. Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ., 130-133.

Марко Поло (2019). Марко Пологийн аялал: Венецийн Рамузиогийн 1559 оны хувилбар. Итали хэлнээс орчуулж, тайлбар бичсэн Г.Бат-Учрал, Элизабетта Рагагин, Самүэла Симион. МУИС-ийн Монгол судлалын хүрээлэн. УБ.

Мөнхбаяр Л., Пүүл Э., Арэнс Б. (2012). Эртний Хархорум хот орчмын гар үйлдвэрлэлийн суурин. *Studia Archaeologica*. Tom. XXXII, Fasc. 17, УБ., 278-290.

Пэрлээ, Х. (1961). Монгол Ард Улсын эрт, дундад үеийн хот суурины товчоон. УБ.

Пэрлээ, Х. (1963). Өмнөговь, Өвөрхангай аймгуудын говь талын нутгаар эртний судлалын хайгуул хийсэн нь. “Эртний судлал-угсаатны зүйн бүтээл”. *Studia Archaeologica*, Tom. II, УБ., 27-35.

Ширайши, Н. (2012). Нүүдэлчдийн төр улс үүсэн бий болоход төмөр нөлөөлсөн нь: Их Монгол улсын үеийн нийгэм улс төр, төмөрлөгийн асуудалд. *Acta Historica*, Tom. XIII, Fasc. 8, УБ., 53-65.

Энхтөр, А. (2025). Монгол Юань улсын үеийн зам харилцаа, улаа өртөө. “Монголын эзэнт гүрэн: Их Юань улсын үеийн археологийн судалгаа”. Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ., 25-40.

Эрдэнэбат, У. (2018). Монголын эртний нийслэл Хархорум. УБ., 2018.

Эрдэнэбат, У., Амарбилэг, Ч., Урангуа, Ж., Хүсэл, Б., Батзориг, О. (2022). Монгол-Японы хамтарсан “Чингис хааны далан: Олон улсын хамтын ажиллагаа” төслийн 2022 оны хээрийн шинжилгээ. - “Монголын археологи-2022”. Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ., 219-226.

Эрдэнэбат, У., Хүсэл, Б., Золжаргал, А., Дашдорж, Б., Футаки, Х., Урангуа, Ж. (2024). Дугшихын балгасанд ажилласан Монгол-Японы хамтарсан экспедицийн тайлан. - “Монголын археологи-2024”. Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. – УБ., 80-82.

Эрдэнэболд, Л., Уртнасан, Э. (2024). Дүүдий Тээгийн суурин. “Монголын эзэнт гүрний өв соёл, түүх ба орчин үе”. Эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүдийн эмхэтгэл. УБ., 185-191.

Erdenebat, U., Husel, B., Zoljargal, A., Dashdorj, B., Futaki, H., Urangua, J. (2025). Interdisciplinary Research

on the Remains of the Silk Road in Mongolia: with a Focus on Dugshikhyn balgas: Report of the Field Survey Team in Mongolia (2024). In: Mongolian and Northeast Asian Studies. Vol. 10/2025, Tokyo, 1-48 (in Japanese).

Osawa, M. (2005). One of the forms of Iron producing in the Mongol Empire obtained from forge-related object found at Avraga site. In: Avraga 1. New Directions in Mongolian Archaeology. Vol. 1, Doseisha, 45-62.

Osawa, M. (2013). Metallurgical analysis results of iron-related artifacts excavated in Mongolia. In: "Iron and the Xiongnu: A paradigm shift in the image of a nomadic nation". In: Proceedings of the 6th International Academic Symposium of the Research Center for the Ancient Iron Culture of East Asia, Ehime University, 69-232 (in Japanese).

Park, Jang-Sik, Reichert, S. (2015). Technological tradition of the Mongol Empire as inferred from bloomery and cast iron objects excavated in Karakorum. In: Journal of Archaeological Science. No. 53, January 2015, 49-60.

Park, Jang-Sik, Honeychurch, W., Amartuvshin, Ch. (2011). Ancient bronze technology and nomadic communities of the Middle Gobi Desert, Mongolia. In: Journal of Archaeological Science. No. 38, 805-817.

Reichert, S. (2020). Craft Production in the Mongol Empire. In: Bonn Contributions to Asian Archaeology. Vol. 9 (=Mongolian-German Karakorum Expedition. Vol. 3). Vor-und Fruehgeschichtliche Archaeologie der Rheinischen Friedrich-Wilhelms-Universitaet Bonn.

Rogers, D., Erdenebat, U., Gallon, M. (2005). Urban centres and the emergence of empires in Eastern Inner Asia. In: Antiquity. Vol. 79, №306, 2005 (December), 801-818.

Received: May 20, 2025; Revised: June 5, 2025; Accepted: June 17, 2025

